



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, татвар хураалтын байдал, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

ХӨА-2017/01-ГА



*Монгол Улсын Ерөнхий аудиторын
2017 оны А/12 дугаар тушаал,
Аймгийн ИТХ-ын захиалга, Хөвсгөл
аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын
баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн
дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн
аудитын тайлан*

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ОРЛОГО
НЭМЭГДҮҮЛЭХ НӨӨЦ
БОЛОМЖ БАЙНА.**

**Хөвсгөл аймаг
Мөрөн хот 2017**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газар	Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй Товчилсон үгийн тайлбар..... .3
Тэргүүлэх аудитор: Г.Оюунгэрэл Утас:99909224	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуурүзүүлэл4
Аудитын менежер:	Аудитын дүн.....5
Г.Эрдэнэчимэг Утас: 99016320	БҮЛЭГ -1. Орон нутгийн орлогын төлөвлөлтөд боломжит нөөц боломжийг ашиглаагүй байна.5-11
Ахлах аудитор: Л. Энх-Амгалан Утас: 96383478	БҮЛЭГ- 2 Орон нутгийн орлого нэмэгдүүлэх нөөц боломж байна.11-15
Ахлах аудитор: Г.Нямлхагва Утас: 96380550	БҮЛЭГ- 3 Дотоод хяналт тавих эрх бүхий байгууллагууд чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.15-16
Аудитор: Л.Магсаржалам Утас: 99039903	Дүгнэлт:
2017оны 07 дугаар сар	Зөвлөмж:
	Холбогдох байгууллагын санал:
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу?	Саналд өгөх тайлбар:
ХАЯГ: (Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын А байр)	
Цахим хаяг: audit.mn	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Тайлал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЕА	Ерөнхий аудитор
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид
ИНХ	Иргэд нийтийн Хурал
ХөААГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
АТЕЗ	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч
АЗД	Аймгийн Засаг дарга
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ААН	Аж ахуйн нэгж
БОУБ	Байгал орчны улсын байцаагч
ТУБ	Татварын улсын байцаагч
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ХХААГ	Хүнс, Хөдөө аж ахуйн газар
АБӨЯХАТ	Авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй шалгуур үзүүлэлт

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, ЕА-ын 2017 оны А/12 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг хангуулж, татвар хураалтыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх болон, орлого нэмэгдүүлэх, шинээр олж болох нуугдмал нөөц боломж байгаа эсэхэд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, гарсан зөрчлийг арилгах, цаашид анхаарч хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг боловсруулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн орлогын төлөвлөлт бодитой, үр ашигтай хийгдсэн эсэх.
- Орон нутгийн орлогын бүрдүүлэлтийг жигд ханган биелүүлж, үнэн зөв тайлагнасан эсэх.
- Дотоод хяналт тавих эрх бүхий байгууллага чиг үүргээ хангалттай хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Хөвсгөл аймгийн ИТХ, АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын алба, Татварын хэлтэс, БОАЖГ, ГХБХБГ болон сумдын ИТХ, Засаг дарга, Санхүүгийн алба, Байгаль орчин тогтвортой хөгжлийн тасгийн байгаль хамгаалагч, газрын байцаагч, Мал эмнэлэг үржлийн тасгийн мал эмнэлгийн улсын байцаагч нарыг хамруулан шалгав.

Аудитын хугацаанд Тосонцэнгэл, Алаг-Эрдэнэ, Мөрөн сумдууд болон Хатгал тосгонд ажиллан бусад сумдаас шаардлагатай материалууд, судалгаа авч шинжлэн судалж аудитын дүнд ашигласан болно.

Аудитын цаг хугацаа, хүний нөөц зэргээс шалтгаалан үйл ажиллагааны орлогын албан татвар, АБӨЯХАТ, улсын тэмдэгтийн хураамж, бууны албан татвар, газрын төлбөр, ойн орлого, усны төлбөр зэрэг орлогуудыг аудитад хамрууллаа.

Аудитын явцад холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал солилцох, ирүүлсэн судалгаа, ИТХ-аар хэлэлцүүлсэн байдал, удирдлагын шийдвэр, холбогдох бусад материалд судалгаа, шинжилгээ хийсний дүнд ерөнхий эрсдлийг **“ДУНД”** гэж үзлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журмыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад

хамрагдсан байгууллагуудаас тайлбар, асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа.

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Г.Эрдэнэчимэг арга зүйгээр хангаж, явцын болон чанарын хяналтыг тавьж, ахлах аудитор Л.Энх-Амгалан, Г.Нямлхагва, аудитор Л.Магсаржалам нар 2017 оны 5 дугаар сарын 01-нээс 2017 оны 07 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл

Хөвсгөл аймгийн орон нутгийн орлогыг: 2015 онд 9572,3 сая төгрөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 9376,5 сая төгрөг, 2016 онд 10033,5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 11394,9 сая төгрөг, 2017 онд 8840,9 сая төгрөгөөр батлагдсан байна.

Хөвсгөл аймгийн 2016 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 03 дугаар тогтоолоор баталсан ба тайлант жилд 3 удаа тодотгол хийсэн байна.

БҮЛЭГ1.

• ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТӨД БОЛОМЖИТ
НӨӨЦ БОЛОМЖИЙГ АШИГЛААГҮЙ БАЙНА.

1.1 Зарим орлогыг төлөвлөөгүй байна.

Орон нутгийн орлогын бүрэлдэхүүн хэсэг үйл ажиллагааны орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, бууны албан татвар, ус ашигласны төлбөр, АБӨЯХАТ, ойн нөөц ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр зэрэг орлогуудыг өмнөх оны гүйцэтгэл, суурь судалгаанд тулгуурлан төлөвлөж байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн орлогод нэмж төлөвлөх дараах нөөц боломжууд байна.

А. Огт төлөвлөөгүй орлогуудаас орлого олох нөөц байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон аймгийн ИТХТ-ийн тогтоолоор батлагдсан орлогуудтай холбоотой дараах орлогуудыг төлөвлөөгүй байна. Тухайлбал:

1. Ус ашиглагчтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгоход¹ тэмдэгтийн хураамжаар орлогыг төлөвлөөгүй байна.

¹ УТХ-ийн тухай хуулийн 35.1.7 “ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд 32 000-80 000 төгрөг, гэрээг сунгахад 20 000-50 000 төгрөг”;

- Ус ашиглагчтай ус ашиглах **Дүгнэлтгүй**² гэсэн шалтгаанаар гэрээ байгуулаагүй байна.
- Ус ашиглагч нарт ус ашиглах зөвшөөрөл олгож гэрээ байгуулах талаар сумдын санхүүгийн тасгийн дарга, татварын байцаагч, байгал хамгаалагч, БОАЖГ-ын холбогдох мэргэжилтнүүдийн ойлголт дутмаг, гэрээ байгуулан орлого олох боломж гаргахад идэвхи, санаачлагагүй ажилласан байна. Байгал хамгаалагч, татварын байцаагч нар ус ашиглагч³ хэрэглэгч хоёрын ялгааг ойлгоогүй өдий хүрсэн байна. *Ус ашиглагчтай гэрээ байгуулан гэрчилгээ олгоход /32.0-80.0 мянга /, гэрээ сунгахад /20.0-40.0 мянга/ 13,6 сая төгрөгийн орлого олох боломж байна.*

2. Мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэх болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход хураах хураамжийн орлогыг 2016 онд 5800,0 мянган төгрөгөөр төлөвлөсөн гэх боловч сумдууд төлөвлөөгүй байна. Тус орлогыг төвлөрүүлэх, ашиглах, хуваарилахад **удирдлагаар** хангаагүйгээс сумдын татварын байцаагч, санхүүгийн албаны дарга, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар энэхүү орлогын талаар ямар ч мэдээлэлгүй байна. Мал эмнэлгүүдэд олгогдсон үнэт цаасны тооцоо бодолтод хяналт тавиагүй, гарал үүслийн гэрчилгээ олгоход авах хураамжийн талаар холбогдох хуулийн этгээдүүдийн ойлголт дутмаг, үнэт цаасны тооцоо бодолт хангалтгүй зэргээс гарал үүслийн гэрчилгээ тутамд аймгийн ИТХТ-ийн 2011 оны 98 дугаар тогтоолоор тогтоосон улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээгээр хураамж аваагүй байна. Хүнс, хөдөө, аж ахуйн сайдын 2005 оны 35 дугаар тушаалаар баталсан “Мал эмнэлэг ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх” журмын 3.1-д заасан ХХААГ үнэт цаасаар хангана гэсний дагуу

- 2014 онд 19350 ш
- 2015 онд 39980 ш
- 2016 онд 34250 ширхэг үнэт цаасыг сумын мал эмнэлэг, үржлийн

нэгжид хуваарилан хүргүүлсэн байна. Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зарцуулалтад тавьж буй хяналт байхгүйгээс гарал үүслийн гэрчилгээний үлдэгдлийг тооцох боломжгүй байна. ХХААГ-аас сумын мал эмнэлэг, үржлийн нэгжид хуваарилсан үнэт цаас бүгд бичигдсэн гэж үзвэл *гарал үүслийн гэрчилгээнээс авах хураамжаар тухайн онуудад 58,0-119,9 сая төгрөгөөр ОНО-д орлого төвлөрүүлэх боломжтой байсан байна.*

² Усны тухай хуулийн 18.1.4.ус ашиглагчид сав газрын захиргааны шийдвэр, энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулах, усны мэдээллийн санд бүртгэх;

³ Усны тухай хуулийн 3.1.27. “ус ашиглагч гэж ашиг олох зорилгоор үйлдэрлэл үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг

Б. Үндсэн мэдээлэл, суурь судалгаа, өмнөх оны гүйцэтгэл зэрэгтэй уялдуулан төлөвлөж байгаа орлогуудад орлого нэмэгдүүлэх дараах нөөц боломжууд байна.

- 1. ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ТАЛААР:** Ашиглалтын лиценз эзэмшдэг 17 аж ахуйн нэгжүүдийн газрын төлбөрийг төлөвлөөгүй байна.
- 2. УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ТАЛААР:** Ус ашиглагчийн бүртгэл, суурь судалгаа гаргаагүйгээс өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан, ямар нөөц боломж байгааг шинжлэхгүйгээр ус ашигласны төлбөрийг төлөвлөж байна. Тухайлбал: Хөвсгөл нуурын усан мандал ашиглан 73 хөвөгч хэрэгсэлээс төлбөр аваагүй, 64 рашаанаас 12 орчмоос нь рашаан ашигласны төлбөрийг тооцож байна. Ус ашиглагч бүртэй гэрээ байгуулах, усны төлбөрийг тооцвол жил бүр орон нутгийн төсөвт 10,0 орчим сая төгрөг нэмэгдэх боломж байна.
- 3. АВТО БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ТАЛААР:** 2017 оны байдлаар гадны дугаартай 571 автомашин байна. Үүнийг “ХӨ” дугаартай болговол 32.2 сая төгрөгийн орлогыг нэмж төлөвлөх боломжтой байна.
- 4. ОЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТАЛААР:** Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөх гол үзүүлэлт утаа гаргадаг айл өрх боловч БОАЖГ-аас ирүүлсэн судалгаагаар 4 сум айл өрхийн 39.0-59.0 хувьд, 5 сум 60.0-69.0 хувьд, 8 сум 70.0- 79.0 хувь буюу аймгийн хэмжээнд нийт өрхийн 79,8 хувьд нь Ойн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт хийсэн байна. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхөд айл өрхүүдийн хамрагдсан хувийг боломжит байдлаар хамруулах, ногдуулсан орлогоо бүрэн төвлөрүүлбэл жил бүр 100 орчим сая төгрөгөөр орлого олох нөөц боломж байна.
- 5. БУУНЫ ТАТВАРЫН ОРЛОГЫН ТАЛААР:** Цагдаагийн байгууллага галт зэвсгийн бүртгэл, хөдөлгөөний мэдээг Татварын албанд ирүүлбэл орлогыг бодитой төлөвлөх, ингэснээр орлого нэмэгдүүлэх боломж байна.

Дээрх боломжуудыг ашиглавал орон нутгийн орлогыг 400 орчим сая төгрөгөөр нэмж төлөвлөх боломжтой байна.

Орлого нэмэгдүүлэх нөөц боломжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт №1-ээс харна уу.

1.2 Аймаг, сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчид нь орон нутгийн орлогын төлөвлөгөөний төсөл, тодотголыг Засаг даргын өргөн мэдүүлснээр баталсан байна.

Шат шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн орлогын төлөвлөгөөний төсөл, тодотголын төслийг орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгаа эсэхийг тооцохгүй, судлахгүй, засаг даргын өргөн мэдүүлснээр хэлэлцэн батлаж байна. Тухайлбал:

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан дараах орлогуудыг боломжит хэмжээнд төлөвлөсөн эсэхийг үл харгалзан хэлэлцэн баталсан байна. Үүнд:

- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу шинээр олгох, шилжилт хөдөлгөөнд олгож байгаа газрын гэрчилгээний тэмдэгтийн хураамжийг Мөрөн сумаас бусад сумдууд 200,0-600,0 мянган төгрөгөөр хэлэлцэн баталсан байна. Жаргалант, Цэцэрлэг сум огт төлөвлөөгүй, Төмөрбулаг, Шинэ-идэр, сумдууд 20,0-30,0 мянган төгрөгөөр төлөвлөн баталсан байна.
- Газрын дуудлага худалдааг 2016 онд 20 суманд зохион байгуулахаар төлөвлөн хэлэлцэн баталсан ч газрын дуудлага худалдаа, төсөл шалгаруулах баримт бичиг хүлээн авахад хураамжийг Мөрөн сумаас бусад суманд төлөвлөөгүй, шат шатны ИТХ-ийн хуралдаанд хэлэлцээгүй байна.
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.5-д заасан “бэлтгэсэн мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгож хураасан хураамжаар 2016 оны байдлаар 24,6 сая төгрөг төвлөрсөн байна. Энэ нь аймгийн хэмжээнд утаа гаргадаг айл өрхөд олгосон эрхийн бичгийн тоотой харьцуулахад 82,8 хувьтай тэнцэж байна.
- Тамхи жижиглэнгээр худалдаалах тусгай зөвшөөрлийн хугацаа 2-3 жил байхад Улаан-Уул суманд 3 жил дараалан 700,0 мянган төгрөгөөр төлөвлөснийг хэлэлцэн баталсан нь үндэслэл муутай байгааг харуулж байна.
- Нотариатын үйлчилгээ, улсын бүртгэлийн үйлчилгээ зэргээс орох орлогыг өмнөх жилүүдийн дунджаар төлөвлөж байгаа гэх боловч зарим сум анхаарал татахуйц байна. Үүнд:
 - ✓ Иргэний бүртгэлийн хураамжийн орлогыг Бүрэнтогтох сум огт төлөвлөж батлаагүй, Арбулаг, Төмөрбулаг, Баянзүрх сумууд 120,0-220,0 мянган төгрөгөөр, бусад сумд 300,0-1500,0 мянган төгрөгөөр баталсан байна.
 - ✓ Нотариатын үйлчилгээний хураамжийг Арбулаг, Баянзүрх сумд 150,0-300,0 мянган төгрөгөөр, бусад сумд 400,0-1800,0 мянган төгрөгөөр баталсан нь харилцан адилгүй байна.
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хэлэлцэхдээ утаа гаргадаг айл өрхүүдийн судалгаа, бодит байдлыг харгалзалгүйгээр хэлэлцэн баталсан байна. Тухайлбал:
 - ✓ Утаа гаргадаг айл өрхийн буюу ногдуулалт хийх айл өрхийн тоог багийн ИНХ болон сумын ИТХ-ын тогтоолоор баталгаажуулахгүй байна.
 - ✓ Арбулаг, Төмөрбулаг Шинэ-Идэр сумд нийт өрхийн 39-50 хувьд ногдуулалт хийсэн байхад зарим нь 80-95 хувьд ногдуулалт хийсэн байна.

Ногдуудалт хийсэн айл өрх:

Ногдуулалт хийсэн айл өрхийн хувь	Сумын тоо	Сумын нэр
39.0 -59.0 хувьд	4	Арбулаг, Хатгал, Төмөрбулаг, Шинэ-Идэр
60.0-69.0 хувьд	5	Баянзүрх, Бүрэнтогтох, Их-Уул, Чандмань-Өндөр, Улаан-Уул
70.0-79.0 хувьд	8	Алаг-эрдэнэ, Галт, Рашаант, Тосонцэнгэл, Түнэл, Ханх, Цагаан-Үүр, Цэцэрлэг
80.0-95.0 хувьд	7	Жаргалант, Тариалан, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Эрдэнэбулган, Мөрөн

Хүснэгтээс харахад: Сумдаар харьцуулахад ойн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт хийсэн нь харилцан адилгүй байна. Аудитын хугацаанд 39.0-59.0 хувьд ногдуулалт хийсэн сумдуудаас тодруулга авахад:

- Айл өрхүүд нь Мөрөн суманд өвөлжөөд зундаа гарч ирдэг тул ногдуулалт хийгээгүй.
- Арбулаг сумын Мөрөн сумтай ойр байдаг 1 ба 2-р багийн айл өрх Мөрөнгөөс түлээгээ авдаг гэж байна.

Энэ байдлаас харахад өвөлдөө Мөрөнд өвөлжөөд буцдаг утаа гаргадаг айл өрхүүдийн бүртгэл Мөрөн сумын утаа гаргадаг айл өрхийн тоонд ороогүй байх магадлал өндөр байна. Ногдуулалт хийсэн айл өрхийн хэрэгцээ шаардлагад тулгуурлаагүй, төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд сумууд нэг өрхөд 8-16 м³ түлээ хэрэглэхээр тооцож төлөвлөсөн байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар харуулбал:

Орон нутгийн орлогын гүйцэтгэл

Орлогын төрөл	сая төгрөгөөр								
	2016 он			2015 он			2014 он		
	төлөв	гүйц	хувь	төлөв	гүйц	хувь	төлөв	гүйц	хувь
Татварын орлого	9544.4	10846.3	113.6	9895.1	9617.7	97.2	8700.5	9139.6	105
Татварын бус орлого	489.1	548.6	112.2	620.4	702	113.2	709.6	903	127.2
Нийт орлого	10033.5	11394.9	113.6	10515.5	10319.7	98.14	9410.1	10042.6	116.3

Жич: Орлогын төлөвлөлт гүйцэтгэлд татварын буцаан олголтын дүнг оруулан тооцов.

Хүснэгтээс харахад: Сүүлийн 3 жилд ОНО-ын төлөвлөгөө 98.1-116.3 хувиар биелсэн байна.

Орлогын биелэлтийг нэр төрлөөр тооцоход: Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 14-26 %-иар, ан амьтны нөөц ашигласны төлбөр 4-175,1 %-иар дээрх онуудад дараалан давж биелсэн байна.

Зарим онуудад үйл ажиллагааны орлогын албан татвар 20,4 %-иар, АБӨЯХАТ 5,2%-иар, улсын тэмдэгтийн хураамж 4,6 %-иар, ойн нөөц ашигласны төлбөр 9,3 %-иар, бууны албан татвар 16,6 %-иар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 42,7%-иар, газрын төлбөр 20,1%-иар тус тус тасарсан боловч дээрх онуудад дараалан тасарсан орлого үгүй байна.

Дээрх байдлуудаас харахад төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд эрх бүхий албан тушаалтнуудын ажлын хариуцлага дутмаг, орлогын гүйцэтгэлтэй уялдуулан төсөвт тодотгол хийж батлагдсан орлогыг хасч төлөвлөх зэрэг нь төсвийн зорилтот түвшин хангаагдахгүйд хүргэж байгааг харуулж байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №-3-т харуулав./

1.3 Аудитын газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулан үндэслэлийн хамт аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Тухайлбал:

- + “Мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход тэмдэгтийн хураамжийн орлогыг төлөвлөх.
- + Ус ашиглагч ААНБ, иргэнтэй гэрээ байгуулж тэмдэгтийн хураамжаар орлого нэмэгдүүлэх. Мөрөн суманд 100 орчим ус ашиглагч, сум бүрт ус ашиглагч байгаа, Хатгалд Хөвсгөл нуурын ус ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа 50 орчим аялал жуулчлалын бааз байгаагаас тэмдэгтийн хураамж тооцож төлөвлөх.
- + Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн 5.3-т заасан зарим ажил үйлчилгээнийг орлогыг нэмэгдүүлэх
- + ОНӨҮГазруудын ашгаас аймагт ногдол ашгийн орлого тооцох, Мөрөн сумын татварын бус орлого тооцох, “Авто замын тухай хууль”-ийн 21.1. заалтыг үндэслэн орон нутгийн замын хураамжийн орлогыг оруулах арга хэмжээ авч орлогыг нэмэгдүүлэх.
- + Авто тээвэр, өөрөө явах хэрэгслийн албан татварын суурь орлогыг нэмэгдүүлэн төлөвлөх.

Төсвийн төлөвлөгөөний төсөлд орлого нэмэгдүүлэхээр өгсөн санал

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	ААГ-ын санал /2015-2017 онуудын төсвийн төсөлд/	2015 он			2016 он		
		төлөв	гүйц	Биелэлт хувь	төлөв	гүйц	Биелэлт хувь
Тэмдэгтийн хураамж	10.0	325.9	311.0	95.4	326.6	370.2	113.3
Усны төлбөр	20.0	49.4	38.1	77.1	26.7	44.5	166.6

АТӨЯХАТ	24.0	437.2	414.3	94.7	390.0	449.9	115.3
Ойн нөөц ашигласны төлбөр	23.4	818.8	742.4	90.6	1033.9	1550.9	150

Хүснэгтээс харахад: Дээрх орлогууд 2016 онд 13.3-66.6 хувиар давж биелсэн боловч төсвийн орлогын төлөвлөгөөнд аймгийн Аудитын газрын саналыг хэрэгжүүлээгүй байна. Төсвийн төсөлд өгсөн дээрх саналууд далд эдийн засгийг илрүүлсэн, хэрэгжих боломжтой, орлого нэмэгдүүлэх эх үүсвэр байгаа талаар зөвлөмж хүргүүлж байсан нь харагдаж байна.

Иймд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга болон эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын ажлын хариуцлага, уялдаа холбоо хангалтгүйгээс орлого олох боломж алдагдсаар байна.

БҮЛЭГ 2 { • ОРОН НУТГИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ НӨӨЦ БОЛОМЖ БАЙНА.

2.1 Орлого олох нөөц боломжийг ашиглахгүйгээс орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг алдсан байна.

Зарим орлогыг өмнөх оны гүйцэтгэл, суурь судалгаанд тулгуурлан төлөвлөсөн ч боломжит орлогуудыг төвлөрүүлээгүй байна.Үүнд:

- Ус ашиглагчийн бүртгэл, төлбөрийн байдал, гэрээ хийгдсэн болон төлбөрөө бүрэн төлсөн эсэхэд судалгаа гаргаагүй, ус ашигласны төлбөрийг орон нутагт төвлөрүүлэх арга хэмжээг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:
 - ✓ Рэнчинлхүмбэ сум “Грийнбрийж” ХХК болон “Инголзолоот” ХХК-аас өөр ус ашиглагчдаас ус ашигласны төлбөр аваагүй байна.
 - ✓ Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа ААН, гуанз, цайны газар зэргийг хамруулаагүй, рашаан ашиглагчдаас Төмөрбулаг, Галт, Түнэл, Рэнчинлхүмбэ, Цагаан-Үүр сумаас бусад сумд рашаан ашигласны төлбөр аваагүй байна.
 - ✓ Хөвсгөл нуурын усыг ашиглагч 73 хөвөгч хэрэгслээс ус ашигласны төлбөр аваагүй байна.
 - ✓ Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28,4 заалтын дагуу ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг Сав газрын захиргаа, БОАЖГ гаргаагүйгээс 29 дүгээр зүйлд заасны дагуу ус ашиглагч бүртэй гэрээ байгуулаагүй, ус ашигласны төлбөрийг орон нутгийн орлогыг төвлөрүүлээгүй байна. Мөрөн сумын нутаг дэвсгэрт ус ашиглагч 28 иргэн аж ахуйн нэгж ус ашигласны төлбөрөө төлөхгүй, ус ашигласаар байна.

- Тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих тусгай зөвшөөрөл олгож гэрээ байгуулсан “Номадик женис” ХХК, “Инголзолоот” ХХК, “Хөвсгөл трейвэл” ХХК, “Грийн бридж” ХХК, “Голын чоно” ХХК зэрэг аж ахуйн нэгжтэй гэрээний биелэлт хангагдаагүй гэдэг шалтгаанаар тул болон бусад загасны төлбөр, хураамжийг гэрээнд тусгагдсан хэмжээгээр орон нутагт бүрэн төвлөрүүлээгүй, биелэлтийг тооцоогүй, гүйцэтгэлд хяналт тавиагүй байна. Тухайлбал:

- ✓ Рэнчинлхүмбэ сумын нутаг дэвсгэрээс 2014-2016 оны байдлаар “Ингол золоот” ХХК, “Грийн бридж” ХХК, “Номадик женис” ХХК, “Идэр тайга” ХХК зэрэг аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээгээр тооцвол агнуурын нөөц ашигласны төлбөр нийт 27,6 сая төгрөгийн орон нутагт төвлөрүүлээгүй байна.
- ✓ Эрдэнэбулган, Баянзүрх, Цагаан-Үүр, Төмөрбулаг сумдууд тул болон бусад загас агнуулахаар байгуулсан гэрээгээр тооцоход тул, бусад загасны төлбөрт 72.4 сая орчим төгрөгийн төлбөрийг орон нутагт төвлөрүүлээгүй байна.
/Хавсралт №4-т харуулав./

- Үйл ажиллагааны орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулах замаар төлөвлөж, татвар төлөгчдөөс сар бүр 6.0, 10.0 мянган төгрөгийг урьдчилсан байдлаар төвлөрүүлж байна. Тайлангийн эцэст татвар төлөгчид цахимаар тайлан илгээдэг, татварын илүү, дутуу төлөлт бараг гардаггүйгээс харахад татвар төлөгчдийн үйл ажиллагааны тайлан үнэн зөв гардаг гэдэг нь эргэлзээтэй байна. Татварын хэлтсийн хяналт шалгалтын тасгаас үйл ажиллагааны орлогод хийсэн шалгалтаар 2014-2016 онд 85 иргэнийг хамруулж 5718,4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулж ажилласнаас харахад үйл ажиллагааны орлогыг үнэн зөв илэрхийлсэн тайланг гаргуулж хэвшвэл орлого олох нөөц боломж байна.

- Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 заалтын дагуу албан татвар төлөгч өөрийн эзэмшилд байгаа галт зэвсгийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлэх, албан татварыг төлөх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна. Тосонцэнгэл суманд гэрчилгээ олгох боломжгүй 10-аад буу иргэдийн гар дээр байгаа ч гэрчилгээжүүлэлт хангалтгүйгээс орлогыг бүрэн төвлөрүүлж чадахгүйд хүргэсэн байна. Ийм нөхцөл байдал бусад сумдад байхыг үгүйсгэх аргагүй байна.

- 2015 онд 155 иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 21,6 сая төгрөг, 2016 онд 195 иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 30,5 сая төгрөг нийт 52,6 сая төгрөгийн газрын төлбөрийн орлогыг бүрдүүлээгүй, Бүрэнтогтох сумын фосфоритын ордод ашиглалтын лиценз эзэмшигчдийн газрын төлбөрийг төлөвлөсөн боловч оруулаагүй, 2016 онд тус орлогыг хасч төлөвлөсөн нь хяналт тавих эрх бүхий байгууллагын ажлын хариуцлагагүйгээс орлого олох боломж алдсан байна.
/Хавсралт №2-т харуулав./

- Газрын төлбөрийн орлогын ихэнх хувийг аж ахуйн нэгжийн эзэмшлийн газрын төлбөрөөс оруулж байгаа ба айл өрхийн эзэмшлийн газрын төлбөрийг бүрэн оруулаагүй байна.

- Орон нутагт зорчиж байгаа иргэн, аж ахуйн нэгжээс “Авто зам, замын байгууламж ашигласны төлбөр хураамж” –ийг наад зах нь 1,0 мянган төгрөгөөр тооцож авбал 7.0 орчим сая төгрөгийн орлого олох боломж байна.

- Гэрээ хийгдээгүй ахуйн хог хаягдалтай хогоо ачуулдаг аж ахуйн нэгж байгууллагыг илрүүлэх хог хаягдлын гэрээг хийх орлого нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тухайлбал: Хог хаягдлын шинэчилсэн гэрээ хийгдээгүй 41 дэлгүүрийн 1 сарын орлого 367,0 мянган төгрөг байна.

Иймд орлого бүрдүүлэх талаар эрх бүхий байгууллагууд чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлбэл орон нутаг орлогоо нэмэгдүүлэх нөөц боломж байна.

2.2 Зарим орлогыг бодитой бүртгээгүй, орлогыг баталгаажуулсан банкны хуулгыг бүрэн ирүүлээгүй байна.

Орон нутгийн орлогын гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 заалтаар анхан шатны баримтыг үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулж бүртгэл хөтлөөгүй байна. Тухайлбал:

1. Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг төлөвлөсөн хэмжээнд бүрэн төвлөрүүлсэн ч орлогын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой тайланг хариуцсан мэргэжилтнүүд гаргаж өгдөггүй, татварын байцаагч нь хяналтаа цаг тухай бүр тавьж орлогоо баталгаажуулахгүй байгаагаас тайлангийн тоо мэдээнүүд зүйл анги /УТХ/ дотроо гүйгдэн зөрүүтэй тайлагнагдаж байна.
2. Ихэнх сумдууд “бэлтгэсэн мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгож хураасан хураамжийн орлогоо түлээ болон хэрэглээгээр салгаж тайлагнаагүй байна. Сумдаас ирүүлсэн тайлангаас хэрэглээний модны гарал үүслийн гэрчилгээнд тэмдэгтийн хураамж аваагүй мэтээр тайлагнасан байна.
3. Сумдын орон нутгийн орлого дансны арилжааны банк дахь хуулгууд орлого, зарлагын гүйлгээ, үлдэгдлийн баталгааны хугацааг тайлант хугацаагаар буюу жилийн нийт дүнгээр тооцоогүй, зөвхөн сүүлийн улирлын байдлаар, хагас жилийн байдлаар зэргээр гаргаж Татварын хэлтэст ирүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.44-т зааснаар хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг банкны хуулгаар бичилт хийж баталгаажуулах гэснийг зөрчсөн байна.

⁴ 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

БҮЛЭГЗ.

- Дотоод хяналт тавих эрх бүхий байгууллагууд чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

3.1 ОНО-ын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих эрх бүхий байгууллага чиг үүргээ хангалттай , үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.

Бүх шатны төсвийн захирагч нар орон нутгийн төсвийн орлогыг төвлөрүүлэх, төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх, тайлагнах төсвийн хэрэгжилтийн талаар чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- Сумдын татварын байцаагч нар нь орлогын төлөвлөлт болон төвлөрүүлтэд хяналт тавьж ажилласан боловч үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.
- Орлогыг боломжит хэмжээнд нь төлөвлөх талаар холбогдох албан тушаалтнуудын хийж буй төлөвлөлтөд чиг үүргээр хангах эрх бүхий Санхүү, төрийн сангийн хэлтсийн хяналт үр дүн муутай байна.
- ХХАА-н Сайдын 2005 оны 35 дугаар тушаалаар баталсан “Мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх журам”-ын 5.1-д “Гэрчилгээний бичилт зарцуулалтад мэргэжлийн хяналтын бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавина” заалтын дагуу сумын мал эмнэлгийн улсын байцаагч хяналт тавиагүй байна.
- Сав газрын захиргаа ус ашиглалтын байдалд тооллого хийсэн боловч сав газрын хэмжээнд ус ашиглалтын байдалд⁵ сав газрын захиргаад байнгын хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- Аймгийн ИТХ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т заасан тухайн жилийн төсөв, түүний тодотголыг хэлэлцэн батлах, хэрэгжилтэнд хяналт тавих, хяналтын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, саналыг тусгаж байгаа эсэхэд орон нутгийн төсвийн удирдлагын талаар эрх, үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны орон нутгийн орлого бүрдүүлэлтэд хийсэн 2016 оны 10 дугаар сарын 28-ны ажлын тайланд орон нутгийн орлого бүрдүүлэлтийн өнөөгийн байдалд тулгуурлан ойн нөөц ашигласны төлбөр, авто тээврийн албан татвар, газрын төлбөр, дуудлага худалдааны орлогын төлөвлөлтөд нэмж бүрдүүлэх 1119,2 сая төгрөгийн нөөц, бололцоо байгаа талаар Аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн зөвлөж ажилласан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба орон нутгийн орлогын төлөвлөлтөнд эрсдлийн удирдлагаар хангахад чиглэсэн, орлого бүрдүүлэлтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж 2017 оноос эхлэн аймгийн Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Авто тээврийн төвийн дарга нартай хамтарсан удирдамж батлуулан ажиллаж байна.

⁵ Усны тухай хуулийн 17.1.10 заалт “ сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах”

3.2 ОНО-ын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээг үр нөлөөтэй хийхгүй байна.

Төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж байгаа боловч орлогын гүйцэтгэлтэй уялдуулан орлого олох нөөц боломж байгаа эсэхэд дүн, шинжилгээ хийгээгүй байна.

3.3 Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулж байна.

Шилэн дансны хуулийн дагуу аймгийн батлагдсан төсөв, төсвийн тодотголыг тухай бүр хуулийн цаглабарт хугацаанд <http://khovsgol.gov.mn> сайтад байршуулсан байна. Аймгийн төсөвт хийсэн төсвийн тодотголыг болон сумдын орон нутгийн орлогод хийсэн тодотголыг цахим хуудсанд байршуулж байгаа боловч төсвийн тодотголыг нэр төрлөөр, эдийн засгийн ангиллаар мэдээлээгүй нь тухайн мэдээлэл ил тод, ойлгомжтой байдлыг төдийлөн хангаагүй байна.

2016 оны хувьд орон нутгийн төсвийн орлогод 3 удаа тодотгол хийсэн боловч тодотгосон орлогыг тусад нь харуулаагүй байна. Тухайлбал:

- ✓ Үйл ажиллагааны орлогыг 55.5/402.7-347.2/ мянган төгрөгөөр хасах, БНАТ-ийн орлогыг 273.7/962.9-1236.6/, бусад орлогыг 87.2/61.6-148.8/ мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон боловч шилэн дансанд тодотгосон зөрүүг тодорхой харуулаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн орлогын болон тодотголын төслийг хэлэлцэн баталж байгаа ч орлогыг бүрэн төлөвлөж байгаа, орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгаа эсэх, төсвийн зорилтод түвшин хангагдаж байгаа эсэх талаар шат шатны Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.
2. Улсын тэмдэгтийн хураамж, байгалийн нөөц ашигласны төлбөр газрын төлбөр, АБӨЯХАТ, бууны татварын орлого зэргээр орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломж байна.
3. Аймгийн иргэдийн Төлөөлөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга болон орлого төлөвлөх, хураах, хяналт тавих эрх бүхий Төрийн байгууллагуудын ажлын хариуцлага, уялдаа холбоо хангалтгүйгээс орлого олох боломж алдагдах, орлогын гүйцэтгэлтэй уялдуулан төсөвт тодотгол хийсээр байна.
4. Аудитын байгууллагаас төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
5. ОНО-ын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих эрх бүхий байгууллага чиг үүргээ хангалттай, үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА Л.ТӨМӨРБААТАР-Т

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн орлогын болон тодотголын төсөлд орлогыг бүрэн төлөвлөж байгаа эсэх, орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн дайчилсан эсэхийг хэлэлцэн төсөв баталж, түүний гүйцэтгэлд хяналт тавьж байх.
2. Сумын ИТХ-ын төлөөлөгчдөд орон нутгийн орлогын төлөвлөгөөний төсөл, тодотголыг хэлэлцэн батлах талаар арга зүйгээр ханган зөвлөн туслах.
3. Багийн ИНХ-ын төлөөлөгчдөд орон нутгийн орлогыг төлөвлөхөд суурь судалгааг гаргах талаар арга зүйгээр хангаж, зөвлөн туслах.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Л.ГАНБОЛД-Д

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн дайчилсан төсөв өргөн мэдүүлж, гүйцэтгэлийг хангуулж байх.
2. Сумын засаг даргыг орон нутгийн орлогыг төлөвлөхдөө нөөц боломжийг бүрэн дайчилсан төсөв боловсруулах арга зүйгээр ханган зөвлөн туслах.
3. Орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг дайчлахад Татварын хэлтэс, БОАЖГ, ГХБХБГ-ын уялдаа холбоог сайжруулж, удирдлагаар хангаж, ус ашиглагчтай гэрээ байгуулах арга хэмжээ авах, тусгай зориулалтаар спорт агнуурын чиглэлээр тул болон загас бариулахаар хийсэн гэрээний биелэлтэд хяналт тавьж байх.
4. Төсөв боловсруулахдаа орлого нэмэгдүүлэх талаар Төрийн аудитын газар болон Санхүүгийн хяналт, аудитын албаны өгсөн саналыг харгалзаж байх.

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн дайчилсан төсөв өргөн мэдүүлж, гүйцэтгэлийг хангуулж байх.
2. Орон нутгийн орлого бүрдүүлэх чиг үүрэг бүхий сумын ТУБ, БОУБ, байгал хамгаалагч, газрын даамал нарыг удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог сайжруулах, ус ашиглагч иргэн, ААН-тэй гэрээ байгуулах арга хэмжээ авах.

3. “Мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход тэмдэгтийн хураамж”-ийн орлогыг төлөвлөн, орон нутгийн орлогод төвлөрүүлэн ажиллах.
4. Тусгай зориулалтаар спорт агнуурын чиглэлээр тул болон загас бариулахаар хийсэн гэрээний биелэлтэд хяналт тавьж гүйцэтгэлийг хангуулж ажиллах.

ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ХУНШАГАЙ-д

1. Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлтийн хэрэгжилтэд хяналт тавьж, ТУБ-дыг аргазүйгээр хангаж ажиллах.

БОАЖГ-ЫН ДАРГА Р.ЖАРГАЛСАЙХАН-д

1. “Тусгай зориулалтаар спорт агнуурын чиглэлээр тул болон бусад загас бариулсан гэрээ”-г дүгнэж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байх.
2. Байгалийн нөөц ашигласны төлбөртэй холбогдуулан айл өрхүүдийн бүртгэл, ус ашиглагчдын бүртгэл, нөөцийн судалгааг гаргаж орлогын төлөвлөлтөнд үр нөлөөтэй ашиглаж байх.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА В.НЭРГҮЙ-д

1. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг хэрэгжүүлэн, орон нутгийн төсвийн төсөл, тодотголд дүгнэлт гаргаж, орон нутгийн орлого төлөвлөж бүрдүүлэхэд эрсдлийн удирдлагаар хангаж ажиллах.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА Ц.АДЪЯАЦЭРЭН-д

1. Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн дагуу галт зэвсгийн бүртгэлд анхаарч хөдөлгөөний мэдээг гаргаж Татварын хэлтэст ирүүлж, хамтарч ажиллах.

Хавсралт №2

**АШИГЛАЛТЫН ЛИЦЕНЗ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН 2013-
2017 ОНЫ ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН НОГДУУЛАЛТ**

/мянган төгрөгөөр/

Ашиглалт ын лиценз эзэмшигч - дийн нэр	Лицен зийн дугаар	Талбайн хэмжээ /га-аар/	1га газрын үнэлгээ	2013 оны ногдуу лалт	2014 оны ногдуу лалт	2015 оны ногдуу лалт	2016 оны ногдуу лалт	2017 оны ногдуу лалт
Топроун хэнцэ ХХК		25	80.0	2000.0	2000.0	2000.0	2000.0	2000.0
Сутай Хэнцэ ХХК	3996А	34	80.0	2720.0	2720.0	2720.0	2720.0	2720.0
Хөвсгөл Зам ХХК	А	26.4	80.0	2112.0	2112.0	2112.0	2112.0	2112.0
Топлаки ХХК		25	80.0	2000.0	2000.0	2000.0	2000.0	2000.0
Дүн		110.4		8832.0	8832.0	8832.0	8832.0	8832.0

Хавсралт № 1

Орлого олох нөөцийн жагсаалт

№	Орлогын нэр	Үндэслэл	ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИТ ДҮН /сая төгрөг/
1	ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ	Малын гаралтай түүхий эдийн худалдан борлуулах болон мал түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг шинжилгээ хийж гарал үүсэл чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход УТХ-ын тухай хуулийн 35.1.21 заалт	58-119.9
		УТХ-ын тухай хуулийн 39.1.6 заалт."газрын дуудлага худалдаа, төсөл шалгаруулах баримт бичиг хүлээн авахад 12 500 төгрөг авах	0.8-1.2
		Нотариат, иргэний бүртгэлийн үйлчилгээний хураамж: Сумдын дундажаар тооцвол 740.0-1500.0 мянган төгрөг, Нотариатын үйлчилгээний хураамжийг зарим сум 150.0-300.0 мянган төгрөгөөр, бусад сумд 400.0-1800.0 мянган төгрөгөөр баталсныг дундаж жишгийг 500.0-800.0 мянган төгрөг гэж тооцвол сум бүрт 100-400.0 мянган төгрөгийг нэмж тооцох боломжтой байна.	2.4-9.6
		Ус ашиглагчтай гэрээ байгуулан гэрчилгээ олгоход: Төвлөрсөн шугамаас ус ашиглан Ус суваг ХХК-тай ус ашигласны төлбөрийн тооцоо хийдэг 78 аж ахуйн нэгж, бусад эх үүсвэрээс ус ашигладаг боловч зөвшөөрөл аваагүй 37 ус ашиглагчид /Мөрөн сумын/, сумдын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг гуанз, цайны газрууд, аялал жуулчлалын чиглэрээр үйл ажиллагаа явуулдаг ус ашиглагчид, бүртэй гэрээ байгуулан гэрчилгээ олговол тэмдэгтийн хураамж авах боломжтой.	4.6
2	УС РАШААНЫ ТӨЛБӨР	Ус ашиглагчтай гэрээ байгуулан ус ашигласны төлбөр авах ба Сав газрын захиргаадын гаргасан тоон судалгаанд үндэслэн ус ашиглагчидтай гэрээ байгуулан ус ашигласны төлбөр авах боломжтой. Тухайлбал:Хөвсгөл нуурын усан мандал ашиглан 73 хөвөгч хэрэгсэл, 64 рашаан тоологдсон байна. Усан мандал ашиглаж байгаа хөвөгч хэрэгсэлүүдээс, 12 рашаанаас бусдаас рашаан ашигласны төлбөр аваагүй байна. /Ус ашиглуулах дүгнэлт гаргуулаагүй/ бизнесийн үйл ажиллагаа явуулж байна. Төвлөрсөн бус эх үүсвэртэй ус ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа Мөрөн сумын 18 иргэн, ААН, бусад сумдад хоолны газар, зочид буудал, амралтын газруудтай ус ашиглах гэрээ байгуулан , ус ашигласны төлбөр ногдуулах боломжтой.	10 орчим
3	ОЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР	Айл өрхүүдийн хамрагдсан хувийг нэмэгдүүлэн боломжит байдлаар хамруулбал, мөн ногдуулсан орлогоо бүрэн төвлөрүүлбэл орлого олох нөөц байна.	100.0 орчим
4	АГНУУРЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР	Гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй, давагдашгүй хүчин зүйлийг баримтжуулаагүй байна. Гэрээнд заасан тул болон бусад загасны тоо, төлбөр хураамжийг сүүлийн 3 жилийн нийлбэр дүнгээр тооцоход нийт 100.0 сая төгрөг төвлөрүүлээгүй байна.	30.0 орчим
	ГАЗРЫН ТӨЛБӨР	Газрын төлбөрийн орлогын ихэнх хувийг аж ахуйн нэгжийн эзэмшлийн газрын төлбөрөөс оруулж байгаа ба гэр хорооллын эзэмшлийн газрын төлбөрийг бүрэн оруулаагүй байна. Энэ нь Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт “Монгол Улсын иргэнийг ахуйн зориулалтаар эзэмшиж, ашиглаж буй О,О7 га хүртэлх хэмжээний газрынх нь төлбөрийн 90 хувиар” /700 м2 газрын 90%-ийг чөлөөлөөд 70 м2 газар газрын төлбөр ногдуулахад жилдээ 700 төгрөг чөлөөлнө/ чөлөөлнө гэж хуульчилсан байдаг. Үүнтэй холбоотойгоор газрын төлбөрийн орлого буурах шалтгаан болж байна.	12.8

“Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, татвар хураалтын байдал, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

5	ГАЗРЫН ТӨЛБӨР	Мөрөн суманд 2015 онд 155 иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 21666.0 мянган төгрөг, 2016 онд 195 иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 30535.6 мянган төгрөг нийт 52201.6 мянган төгрөгийн газрын төлбөрийн орлогыг жилд нь барагдуулж бүрдүүлээгүй байна.	26.1
	ГАЗРЫН ТӨЛБӨР	Бүрэнтогтох суманд ашиглалтын лиценз эзэмшдэг 17 аж ахуйн нэгжүүд газрын төлбөрөө төлөөгүй байна. Тухайлбал: Топроун хэнцэ ХХК 2.0 сая төгрөг, Сутай Хэнцэ ХХК 2.7 сая төгрөг, Хөвсгөл Зам ХХК 2.1 сая төгрөг, Топлаки ХХК 2.0 сая төгрөг зэрэг байна.	9
6	Замын хураамж	Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжаас хураамж авбал 10.0 орчим сая төгрөгийг орон нутагт төвлөрүүлэх боломжтой байна. Жилд дунджаар 14,0-15,0 мянган иргэн зорчино гэж бодоход нийт 10,0 сая төгрөг оруулахаар тооцоо гарч байна. Улсын болон орон нутгийн чанартай зам, замын байгууламжаар зорчиж байгаа иргэн, аж ахуйн нэгжээс “Авто зам, замын байгууламж ашигласны төлбөр хураамж” авбал 6,7 сая төгрөгийн орлого олох боломж байна.	16.7
7	АТӨЯХАТ	Өмнөх жилээс Гадны дугаартай авто машины татвар болох 290 иргэний 13.7 сая төгрөг татварын албаны дансанд орсон татварын орлого бусад аймаг, дүүргийн татварын дансанд шилжих тул 2017 оны төсвийн төслийг 387.8 сая төгрөг буюу өмнөх оноос 2.1 сая төгрөгөөр буурч төлөвлөгдөж байна.	13.7
	АТӨЯХАТ	2017 оны байдлаар гадны дугаартай болон Улаанбаатар хотод бүртгэлтэй авто машины татвар болох 571 иргэний 32.2 сая төгрөгийн татварын орлого аймаг, дүүргийн татварын дансанд шилждэг тул Хөвсгөл аймгийн дугаартай болгоход аймгийн орлого нэмэгдэнэ. Мөн эдгээр машины 30% нь 2017 онд багтааж ХӨ дугаартай авах боломжтой гэж үзвэл 6.4 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна.	6.4
8	БУУНЫ ТАТВАР	Цагдаагийн байгууллага галт зэвсгийн бүртгэл, хөдөлгөөний мэдээг бодитой гаргаж, бүртгэлжүүлэх арга хэмжээ авбал бүртгэлгүй галт зэвсгээс албан татвар авбал орлого нэмэгдэх боломжтой байна. Тосонцэнгэл суман бүртгэлгүй, гэрчилгээ авах боломжгүй 10-аад галт зэвсэг тоологдсон байна. Бусад сумдад дунджаар 10 орчим бүртгэлгүй галт зэвсэг байна гэж тооцвол татварт хамруулах арга хэмжээ авбал орлого нэмэгдэх боломжтой байна.	7
9	Хог хаягдал	Гэрээ хийгдээгүй ахуйн хог хаягдалтай хогоо ачуулдаг аж ахуйн нэгж байгууллагыг илрүүлэн хог хаягдлын гэрээг хийж ажиллаагүй байна. Жнь: Хог хаягдлын шинэчилсэн гэрээ хийгдээгүй 41 дэлгүүр 367,0 мянган төгрөг байна.	4.8
Нийт			297-391.8 сая орчим

“Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, татвар хураалтын байдал, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

Хавсралт№3

Хөвсгөл аймгийн татварын орлогын биелэлт
/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2014 он		Гүйц хувиар	2015 он		Гүйц хувиар	2016 он		Гүйц хувиар
		төлөв	гүйц		төлөв	гүйц		төлөв	гүйц	
1	Цалин түүнтэй адилтгах орлого	6,055.0	6,071.2	100.3	6,405.0	6,260.1	97.7	6,231.5	6,561.0	105.3
3	Үйл ажиллагааны орлого	258.4	476.5	184.4	480.6	382.4	79.6	347.2	477.4	137.5
4	Хөрөнгө борлуулсны орлого	90.6	79.9	88.2	99.8	45.4	45.5	53.7	57.2	106.5
5	Шууд бус орлого	73.0	125.8	172.2	103.0	139.0	134.9	148.8	184.0	123.7
6	ОТБТБАҮХЭИргэний ОАТатвар	21.1	16.1	76.3	21.0	8.7	41.7			
7	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	320.0	368.3	115.1	319.3	363.8	114.0	319.3	403.2	126.3
8	Бууны албан татвар	11.2	12.5	112.2	11.6	12.8	110.4	84.5	70.4	83.4
9	АТБӨЯХэрэгслийн албан татвар	395.3	416.0	105.3	437.3	414.4	94.8	390.0	449.9	115.4
10	Улсын тэмдэгтийн хураамж	296.2	297.0	100.3	325.9	311.0	95.4	326.6	370.2	113.4
11	Түгээмэл тархацтай АМАТ	41.5	23.8	57.3	43.5	43.4	99.8	21.6	29.7	137.5
12	Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	144.8	149.5	103.2	154.1	123.3	80.0	161.9	165.8	102.4
13	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	4.3	1.3	30.2	136.3	231.1	169.5	0.3	0.4	141.1
14	Бусад татвар	6.6	6.0	91.5	10.2	2.8	27.6	-	-	
15	Газрын төлбөр	272.3	217.4	79.9	263.3	223.3	84.8	150.0	214.6	143.0
16	Дуудлага худалдаа	52.6	79.6	151.2	70.1	66.0	94.1	70.1	24.8	35.4
17	Ойн нөөц ашигласны төлбөр	653.5	741.6	113.5	818.8	742.5	90.7	1,034.0	1,550.9	150.0
18	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	25.9	71.4	275.1	122.8	128.3	104.4	150.5	207.1	137.6

“Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, татвар хураалтын байдал, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

19	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	47.8	54.0	113	49.4	38.1	77.1	26.8	44.5	166.3
20	Байгалийн ургамлын НАТөлбөр	21.3	11.8	55.4	23.1	81.2	351.3	25.4	28.2	111.1
Татварын орлогын дүн		8,791.18	9,219.57	105.4	9,895.2	9,617.7	97.2	9,542.1	10,839.4	113.6
26	Хувьцааны ногдол ашиг	103.0	102.5	99.5	104.2	104.2	100.0	62.2	42.2	67.9
28	Хүү, торгуулийн орлого	388.5	446.2	114.8	449.7	381.2	84.8	375.2	446.6	119.0
29	Түрээсийн орлого	0.0	0.7		-	0.7				
30	Бусад орлого	1.7	106.0	6,258.10	21.3	163.5	769.3	15.3	25.5	166.5
31	Төрийн болон ОНӨ бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	42.0	46.3	110.3	45.1	52.4	116.1	36.4	34.3	94.3
36	Төсөвт байгууллагын өөрийн орлого	83.8	121.5	145.1	269.1	248.7	92.4			
Татварын бус орлогын дүн		619.0	823.2	133	889.5	950.7	106.9	489.1	548.7	112.2
Нийт орлогын дүн		9,410.2	10,042.7	107.4	10,784.6	10,568.4	98.0	10,031.2	11,388.1	113.5

“Орон нутгийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, татвар хураалтын байдал, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

Хавсралт №4

Тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих тусгай зөвшөөрлөөс орсон орлого, гэрээний дүн

/сая төгрөгөөр/

ААН нэр	Төрөл	сумы н нэр	Байгуулсан гэрээ		гэрээний биелэлт		зөрүү	Байгуулсан гэрээ		гэрээний биелэлт		зөрүү	Байгуулсан гэрээ		гэрээний биелэлт		зөрүү	Зөрүү	
			2016 он					2015 он					2014 он					тоо	төлбөр
			тоо	Төл бөр	тоо	төлбөр		тоо	төлбөр	тоо	төлбөр		тоо	төлбөр	тоо	төлбөр			
Ингол золоот	тул загас	Баянз үрх	79.0	15.7	55.0	28.6	24.0	50.0	8.7	40.0	7.0		65.0	10.4	65.0	10.4		34.0	
	бусад загас	Рэнч инлх үмбэ	790.0	26.3	550.0		240.0	500.0	14.9	100.0	2.9		650.0	17.3	350.0	12.6		940.0	
Нийт				42.0		28.6	13.4		23.6		9.9	13.7		27.7		23.0	4.7		31.8
